



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/76

Биндэр сум

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд
дундаа хамтран өмчилсөн газрыг
гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн эрх шилжүүлэх гэрээ, хэлцлийг харгалзан газрыг 1 дүгээр хавсралтад дурдсан 3 иргэнд 5183 м2 газрыг үнэ төлбөргүй шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2.Гэр бүлийн нэг гишүүний өмчилж авсан газарт энэхүү захирамжийг үндэслэн газрын кадастр хийх, газар өмчлөгчид хүлээлгэн өгөх, хилийн заагийг газар дээр нь тэмдэгжүүлэх, улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2007 оны А/30, 2010 оны А/78 тоот захирамжуудын холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Газраа шилжүүлсэн иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

